Сумын ГХУСАЗСЗ-ийн 2020 оны 01 дүгээр
сарын 27-ны өдрийн 01 дүгээр тогтоолын хавсралт

ӨЛЗИЙТ СУМЫН ГХУСАЗСЗ-ИЙН 2020 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилт:

Иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах орчинг бүрдүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хууль сурталчлах болон зорилтот бүлгүүдэд чиглэсэн сургалт, арга хэмжээг нэгдсэн бодлогоор зохион байгуулж, энэ ажилд иргэд, байгууллага, аж ахуйн нэгж, хуулийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог хангах, үйл ажиллагааг нь эрчимжүүлэх ажлыг шуурхай, ил тод, хариуцлагатай, хүртээмжтэй, үр дүнтэй зохион байгуулна.

Д/д	Хийгдэх ажил	Шалгуур үзүүлэлт	Хугацаа	Хэрэгжүүлэгч байгууллага, эзэн
1	2	3	4	5
Нэг. Зохион байгуулалтын талаар				
1.1	“Архидан согтуурахтай тэмцэх аян”-ыг сумын хэмжээнд зохион байгуулах	Аянг зохион байгуулж үр дүнд хүрсэн байх.	Жилдээ	Сум, баг, байгууллагын дарга эрхлэгч нар
1.2	Аливаа баяр ёслол, тэмдэглэлт арга хэмжээ, аялал зугаалгыг архидалтгүйгээр зохион байгуулах.	Сум, баг, байгууллага, ААН, иргэдэд сурталчилж мөрдөж хэрэгжүүлснээр.	Жилдээ	Сум, баг, байгууллагын дарга эрхлэгч нар
1.3	Архинд хэт донтсон иргэдийн судалгааг нарийвчлан гаргаж, архинаас гаргах боломжит бүх арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх.	Архинаас татгалзсан иргэдийн тоо нэмэгдсэнээр.	Жилдээ	Сум, баг, байгууллагын дарга эрхлэгч нар
1.4	Шаардлагатай газруудад гэрэлтүүлгийг нэмж байрлуулах.	Хайрханы 1-р гудамж, Цагаан хөтлийн урд гудамжинд	Жилдээ	Сумын Засаг дарга ЗДТГ
1.5	Иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор нохой устгалын ажлыг зохион байгуулах.	Устгалын ажил хийгдсэнээр	Жилдээ	ЗДТГ
1.6	Сумын төвийн камерын ашиглалтыг сайжруулах, бүх байгууллагууд камертай болно. Камерын ашиглалтын талаарх судалгааг гаргуулан авах.	Зөрчлөөс урьдчилан сэргийлэх	2 дугаар сард	Байгууллагын дарга эрхлэгч нар Олон нийтийн цагдаа 6 дугаар багийн Засаг дарга
1.7	Хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэн бүр өөрсдөөс шалтгаалах арга хэмжээг авч ажиллах талаарх зөвлөмж, мэдээллээр хангаж ажиллах	Хөршийн холбоо сайжирснаар	Жилдээ	Багийн Засаг дарга нар Сайн дурын идэвхтэн
1.8	“Сургуулийн цагдаа” эргүүлийн үйл ажиллагааг тогтмолжуулан журмын дагуу явуулах.	Сургууль орчинд гэмт хэрэг зөрчилгүй ажилласнаар	Жилдээ	ЕБС-ийн захирал Олон нийтийн цагдаа Сургуулийн нийгмийн ажилтан
1.9	Хамтарсан багийн ажиллах журмыг батлах	Журам батлагдсанаар	Жилдээ	Сумын Засаг дарга ЗДТГ

1	2	3	4	5
1.10	Гэмт хэрэг, зөрчлийн талаар удирдлагуудад мэдээллийг тогтмол өгч байх.	Сар бүрийн 15-нд ИТХ, Засаг даргад мэдээлэл хийснээр	Жилдээ	Хэсгийн төлөөлөгч, цагдаа
1.11	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх зөвлөлийг шинэчлэн байгуулж даргыг сонгох.	Зөвлөлийг шинэчилж даргыг сонгосноор	Жилдээ	Сумын Засаг дарга
2. Сургалт сурталчилгааны талаар				
2.1	Авлигын хор уршгийг олон нийтэд сурталчлах, авлигаас ангид байх соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах.	Сургалт, сурталчилгааг хийж зөрчилгүй ажилласан байх.	Жилдээ	Сум, баг, байгууллагын дарга эрхлэгч нар
2.2	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах байгууллагын дотоод хяналтын тогтолцоог бий болгох.	Зорилтот хүмүүст чиглэсэн сургалт зохион байгуулж хяналт тавьснаар.	Жилдээ	ИТХ, ЗДТГ-ын ЭБАТ-ууд
2.3	Хүүхдийн хүмүүжил, гэр бүлийн үнэ цэнэ, ГХУС-д иргэн бүрийн оролцоо сэдэвт сургалтуудыг иргэний боловсролын цагаар зохион байгуулна.	Сургалтыг зохион байгуулсанаар	Жилдээ	Байгууллагын дарга эрхлэгч нар, сургагч багш нар
2.4	Цахим орчинд үйлдэгддэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт сурталчилгааг хийж ухаалга гар утаснаас татгалзуулж шатар, Монгол наадгайгаар тоглох хөдөлгөөнийг үргэлжлүүлэх.	Иргэдийн хууль зүйн мэдлэг дээшилж, аливаа хууль бус үйлдлээс өөрсдийгөө хамгаалах чадвар дээшилнэ.	Жилдээ	ГХУСАЗСЗ Сумын ЗДТГ
2.5	Өсвөр насны хүүхдийг бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, харилцаа хандлага, архи, тамхины хор хөнөөл, авилгыг үл тэвчих зан үйлд сургах, зөв дадал, хандлагыг төлөвшүүлэх ажлыг насны онцлогт тохирсон сургалтыг хичээлийн хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх.	Сургалт зохион байгуулснаар	Жилдээ	ЕБС-ийн захирал Хамтарсан баг, Насан туршийн боловсролын төв Олон нийтийн цагдаа ЭМ-ийн төв
2.6	Мотоциклийн жолооч иргэдэд зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор А ангилалын сургалтыг зохион байгуулан үнэмлэхжүүлэх, насанд хүрээгүй хүүхдүүдээр машин, мотоцикол унуулахгүй байх.	Мотоцикол унадаг хүн бүр үнэмлэхтэй болсноор	4-5 дугаар сард	ГХУСАЗСЗ Сургуулийн захиргаа Цагдаагийн хэсэг
2.7	“Хүүхэд хамгаалалд эцэг эхийн үүрэг оролцоог хангуулах жил”-ийн хүрээнд гэр бүлийн хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд иргэдийн оролцоог сайжруулах зорилгоор эрчүүд, эмэгтэйчүүд, охид, хөвгүүдэд зориулсан сургалтуудыг зохион байгуулна.	Сургалт зохион байгуулснаар	Жилдээ	ГХУСАЗСЗ Сумын Засаг дарга Хамтарсан баг
2.8	Өсвөрийн цагдаа бүлгийн сурагчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хамтран ажиллах	Бүлгийн үйл ажиллагаа сайжирснаар	Жилдээ	Хэсгийн төлөөлөгч, Сургуулийн нийгмийн ажилтан

1	2	3	4	5
2.9	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр ард иргэдэд сургалт сурталчилгааг тогтмолжуулах	Сургалт зохион байгуулснаар	Жилдээ	ГХУСАЗСЗ Сумын Засаг дарга Хамтарсан баг
3.Хяналт шалгалтын талаар				
3.1	Согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээний газруудад хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлыг ТББ, иргэдтэй хамтран зохион байгуулах	Хяналт шалгалт явагдсанаар	Байнга	Хэсгийн төлөөлөгч, цагдаа, олон нийтийн цагдаа
3.2	Хүрээлэн буй байгаль орчны эсрэг хууль бус үйлдлийг таслан зогсоох чиглэлээр эргүүл ажиллуулах, шалгалт хийх.	Эргүүл гарч шалгалт хийснээр	Жилдээ	ГХУСАЗСЗ, ЗДТГ, БОХУБ, Байгаль хамгаалагч багийн Засаг дарга нар, хэсгийн төлөөлөгч
3.3	Төрийн болон төрийн бус байгууллага аж ахуйн нэгжүүд аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор тэмдэглэлт өдрүүд болон онцгой үеүүдэд ажилтан, албан хаагчдыг эргүүл, жижүүрт гаргах, төв зам дагуу эргүүлд гарах ажлыг зохион байгуулах.	Эргүүл хийсэн тэмдэглэлээр	Жилдээ	Сумын Засаг дарга Баг, байгууллагын дарга эрхлэгч нар Цагдаагийн хэсэг
3.4	Хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр хяналт шалгалтыг тогтмолжуулах	Хяналт шалгалт хийгдсэнээр	Жилдээ	Сумын Засаг дарга Сумын ХЭАХН
3.5	Гэмт хэрэг үйлдэж болзошгүй иргэн, бүлэг, эрсдэл бүхий газарт тогтмол хяналт тавьж ажиллах	Тогтмол хяналт тавих	Жилдээ	Хэсгийн төлөөлөгч, цагдаа, олон нийтийн цагдаа
3.6	Зам тээврийн осол гарч байгаатай холбогдуулан улсын чанартай авто зам дээр хяналт шалгалтыг тогтмол хийх, жолооч нарт анхааруулга, сануулга сэрэмжлүүлэгийг тухай бүрт өгч зөрчлийг арилгуулах.	Эргүүл хийгдэж, осол авар буурсан байх	Жилдээ	ГХУСАЗСЗ Цагдаагийн алба хаагчид
4. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар				
4.1	Малчдын бүлгийн ахлагч, бүлгийн гишүүдийг шинэчлэх, үйл ажиллагааг эрчимжүүлэх, бүлгийн гишүүдийг гарын авлагаар хангах.	Малчдын бүлгийг шинэчлэн байгуулж үйл ажиллагаа тогтмолжсоноор	2 дугаар улирал	Сумын Засаг дарга Багийн Засаг дарга нар Хэсгийн төлөөлөгч
4.2	Малын хулгайг бууруулах зорилгоор бог, бод малын ээмэг, им тамганы шинэчилсэн бүртгэлийг гаргаж сумын удирдлага болон хөрш зэргэлдээ сумдтай цахим мэдээлэл солилцож ажиллах.	Шинэчилсэн бүртгэлтэй болж хөрш зэргэлдээ сумдтай мэдээлэл солилцох.	Жилдээ	Сумын Засаг дарга Багийн Засаг дарга нар Мал эмнэлгийн тасаг Хэсгийн төлөөлөгч
4.3	Бод малыг байнгын хариулга маллагаатай болгох, адууг оторлох зохион байгуулалтын арга хэмжээг судлан хэрэгжүүлэх.	Хяналт сайжирна.	Жилдээ	Сумын Засаг дарга Багийн Засаг дарга нар ГХУСАЗСЗ
4.4	Мал бүхий иргэдэд хууль эрх зүйн гарын авлага, сэрэмжлүүлэг мэдээллээр хангах.	Гарын авлагаар хангах.	Жилдээ	ЗДТГ, хэсгийн төлөөлөгч Багийн Засаг дарга нар

1	2	3	4	5
4.5	Намар, өвлийн эрсдэлт цагаар хөдөлгөөнт эргүүлийг ажиллуулах.	Хөдөлгөөнт эргүүл ажилласнаар	3,4 дүгээр улиралд	Сумын Засаг дарга Багийн Засаг дарга нар Хэсгийн төлөөлөгч, цагдаа, олон нийтийн цагдаа
4.6	Мал мах бэлтгэх үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах.	Хяналт сайжирна.	Жилдээ	Сумын Засаг дарга Багийн Засаг дарга нар Мал эмнэлгийн тасаг Хэсгийн төлөөлөгч, цагдаа, олон нийтийн цагдаа
		5.Бусад ажил		
5.1	“Ногоон гэрэл цагаан шугам” тэмцээнийг цэцэрлэгийн бэлтгэл бүлэг, ЕБС-ийн 1-р ангиудын хооронд зохион байгуулах	Тэмцээн зохион байгуулснаар	10 дугаар сард	Сумын ГХУСАЗСЗ Ирээдүй цэцэрлэг Сайн-Оюут сургууль
5.2	Хурдан морины уралдааны хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалж хувцас хэрэглэлийг зохих журмын дагуу ашиглаж байгаад хяналт тавих. Багууд уралдаан тэмцээн зохион байгуулахдаа холбогдох шийдвэрийг хууль журмын дагуу гаргуулсан байх.	Хүүхдийг гэмтэл бэртлээс урьдчилан сэргийлнэ	07 дугаар сард	Хамтарсан баг ГХУСАЗСЗ Багийн Засаг дарга нар Уяачдын холбоо
5.3	Гэр бүлийн өдрөөр “Миний гэр бүлийн бахархал-Аав” эсээ бичлэг болон, гар зургийн уралдааныг удирдамжийн дагуу зохион байгуулах	Аавуудын гэр бүл дэх үүрэг оролцоо сайжирна.	5 дугаар сард	ГХУСАЗСЗ Хамтарсан баг
5.4	Цагдаагийн хэсгийн алба хаагчдыг ажиллах нөхцөл боломжоор хангах	Ажиллах нөхцөл сайжирсанаар	Жилдээ	ГХУСАЗСЗ Сумын Засаг дарга

---oOo---